



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗАР**

**СОЁЛЫН САЙДЫН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН  
ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**2024 ОН**

**СОЁЛЫН САЙДЫН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН  
ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 7 дугаар сарын 3 -ны өдөр

Сайншанд сум

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Соёлын сайдын Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд "Хамтран ажиллах гэрээ", түүний хавсралтад тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлага болон хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах, цаашид соёлын салбарын үйл ажиллагааг орон нутагт үр нөлөөтэй зохион байгуулахын тулд төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээний ажлыг зохион байгуулав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Соёлын сайд болон Аймгийн Засаг даргын 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийн тайланд бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс тодруулга авах, бодит гүйцэтгэлийг нягтлан шалгах зэрэг аргуудыг хэрэглэн хяналт, шинжилгээ үнэлгээг хийлээ.

Тус бодлогын баримт бичгийн 6 зорилтын 35 арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, зорилт арга хэмжээ бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

№	Гэрээний нэр	Биелэлт тооцох арга хэмжээний тоо	Биелэлтийн хувь							Дундаж хувь
			100 %	90 %	70 %	50 %	30 %	0 %	ХБ	
1	Салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, цахим шилжилтийг дэмжих чиглэлээр	5	1	2					2	93.3 %
2	Соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр	9	6	2			1			90 %
3	Урлаг, уран бүтээлийг хөгжүүлэх чиглэлээр	6	3	3						95 %
4	Соёлын өвийг хадгалж, хамгаалах чиглэлээр	5	3				1		1	82.5 %
5	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр	4		1	2	1				70 %
6	Соёлын бүтээн байгуулалт, хөрөнгө	6		2	2			2		63.3 %

оруулалтын чиглэлээр									
<b>Нийт</b>	<b>35</b>	<b>13</b>	<b>10</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>75.3 %</b>

### Дөрөв. Дүгнэлт

Соёлын сайд Дорноговь аймгийн Засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг хангаж, дараах ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг сурталчлан таниулах зорилгоор “Монгол гэр” үзэсгэлэн арга хэмжээнд уламжлалт гар урлалын өвлөн уламжлагчдын бүтээл халх угсаатны модон сийлбэртэй их 8 ханатай гэрийг сурталчлан алдаршууллаа. Үзэсгэлэнгээр зочилсон зочдын тоо 10000 гаруй, боловсролын хөтөлбөрт 2000 гаруй хүн хамрагдсан. Тус арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны А/393 дугаар захирамжаар 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Сумдын соёлын төвүүд хагас жилийн байдлаар 15 кино гаргаж, 800 гаруй иргэнд үзүүлсэн. Аймгийн “Gobi cinema” кино театр 32 кино гаргаж, 7044 иргэнд үйлчиллээ. Хагас жилийн байдлаар кино урлагаар дамжуулан 7844 иргэнд соёлын боловсрол олголоо. Кино урлагаар үйлчлүүлсэн иргэдийн тоо 2023 оноос 66,4%-иар өссөн.

Аймгийн хэмжээнд 35 дах удаагийн “Үндэсний бичиг соёл, номын баяр-2024” арга хэмжээг “Илүү их уншъя” уриан дор 2024 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулж “Олуулаа уншъя” аян, орон нутгийн зохиолч, яруу найрагчдын уулзалт, шинэ номын нээлт зэрэг 22 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 2250 гаруй иргэдийг хамруулсан нь өнгөрсөн оноос 1250 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна. Уг үйл ажиллагаанд нийт 3,3 сая төгрөг зарцууллаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхандулаан сумын соёлын төвд 59,0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, Даланжаргалан, Хатанбулаг сумдад 80,0 сая төгрөгөөр лед дэлгэц, Өргөн суманд 114,0 сая төгрөгөөр хөгжим, техник хэрэгслийг тус тус худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр “Эвт Мэргэн Өвгөн Эх Чоно хоёрын домог” хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд, “Чандмань Эрдэнэ” хүүхдийн жүжгийг ерөнхий боловсролын сургуулийн 650 сурагчдад үзүүлж хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, бие биенийгээ хүндлэх соёлыг түгээсэн. 2024 оны хагас жилийн байдлаар хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн 30 гаруй арга хэмжээ зохион байгуулж, 40 гаруй ААН байгууллага, төрийн болон хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, 20000 гаруй иргэдийг соён гэгээрүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор батлагдсан “Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д Дорноговь аймгаас түүх соёлын үл хөдлөх 6 дурсгал улсын хамгаалалтад бүртгэгдсэн. Тайлант оны эхний хагас жилд Сайхандулаан сумын нутагт орших “Хар хөтлийн палеонтологийн дурсгалт газар”, Мандах сумын нутаг дэвсгэрт орших Өлгий хийдийг хариуцуулан хамгаалуулах гэрээ байгуулж аймгийн хэмжээнд улсын хамгаалалтад орсон 6 үл хөдлөх дурсгалыг иргэдэд 100% гэрээгээр хариуцуулан хамгаалууллаа.

Тайлант оны хагас жилийн байдлаар аймгийн хамгаалалт бүхий 14 дурсгалыг иргэн хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулж ажиллалаа.

Тав. Үнэлгээ

Соёлын сайд аймгийн Засаг дарга нарын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлт тооцох 6 зорилтын 35 арга хэмжээнээс

- ✓ 13 арга хэмжээг “Үр дүнтэй”
- ✓ 14 арга хэмжээг “Тодорхой үр дүнд хүрсэн”
- ✓ 5 арга хэмжээг “Эрчимжүүлэх шаардлагатай”
- ✓ 3 арга хэмжээг “Хугацаа болоогүй” гэж дүгнэн, эхний хагас жилийн биелэлтийн дунджийг 75.3 % буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

Зургаа. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж

Соёлын сайд Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн боловч дараах арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- ✓ Хэрэгжилтийг тайлагнахдаа МУЗГ-н 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын А/675 дугаар захирамжаар тус тус батлагдсан журмын дагуу заасан хугацаанд, үр дүнд суурилсан тайланг бодит тоон мэдээлэлд тулгуурлан бичих
- ✓ Тайланг бичихдээ тайланд тавигдах стандартыг бүрэн хангах /Оршил хэсэг, Үндсэн хэсэг, Дүгнэлт хэсэгтэй байх/
- ✓ Хэрэгжилтэд гарсан өөрчлөлт, ахиц үр дүнг заавал тоон мэдээлэлтэй бүрэн тайлагнах, бодитой үнэлэгдэхүйц тайлагнах шаардлагатай.
- ✓ Өөр арга хэмжээг холбож нуршиж бичихгүй байх, мэдээ мэдээлэл биш тайлан хэлбэрээр бичихэд анхаарах
- ✓ Хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт арга хэмжээг эрчимжүүлэх. Тухайлбал:
  - Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зусланд нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах үйл ажиллагаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх
  - Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг зохион байгуулах
  - Эрдэнэ болон Дэлгэрэх сумдын Соёлын төвийн барилгын явцыг нэмэгдүүлэх

ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА

У.ГАНБААТАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК

МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.НАРАНЖАРГАЛ

